

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Маш бага орлоготой, мэргэжилгүй, энгийн ажил эрхэлдэг ажилчид орчин үеийн нийгмийн давхраажилтын аль ангид хамаарах вэ? /1 оноо/
 А. Дундын дунд
 В. Ядуу ажилчин анги
 С. Доод анги
 D. Ёроол хэсэг
2. Энгийн хөдөлмөрийн багаж зэвсэг ашиглан тариалангийн аж ахуй эрхэлдэг ч, нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, ураг төрлийн холбоонд суурилсан, олон төрлийн овгуудаас тогтох нийгмийн хэв маяг аль нь вэ? /1 оноо/
 А. Ан агнуурын нийгэм
 В. Газар тариалангийн нийгэм
 С. Цэцэрлэг аж ахуйн нийгэм
 D. Аж үйлдвэржсэн нийгэм
3. Доорх өгөгдлөөс Т.Билтон нарын судлаачид “Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм”-ийн хэв маягт хамаарах ойлголтуудыг сонгоорой. /2 оноо/

1. Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар өрх, гэр бүлийн хүрээ байна.
2. Газар тариалангийн аж ахуй болон түүнээс өмнөх хэлбэрийн аж ахуйтай.
3. Хувийн хүсэл зориг гэхээсээ хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг
4. Угсаа залгамжлах ёс бүхий хаант засаглал эсвэл төрийн бүтэцтэй.
5. Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй.
6. Хамт олны зарчимд гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.

- А. 2, 4 В. 1, 5 С. 3, 5 D. 5, 6

4. Социализмын үеийн Монголын нийгмийн давхраажилтад хамаарах жишээ болон нийгмийн давхраажилтын тухай ойлголтыг зөв тодорхойлсон мөрийг олоорой. /3 оноо/

Мөр	Жишээ	Нийгмийн давхраажилт
Хүснэгт-а	Жирийн малчин ард нь хошуу ноёд, тайж нар, хутагтад харьяалагдан, тэдэнд татвар нийлүүлэх, мал сүргийг нь адгуулан үржүүлэх үүрэг хүлээж байв.	Дээд давхраа - хошуу ноёд, тайж, лам; Дунд давхраа – жирийн малчин ард; Доод давхраа – гэрийн боолчууд
Хүснэгт-б	Хамтын зарчимд нийцүүлэн амьдардаг бөгөөд бүгдээрээ тэгш байдалтай оролцдог. Мөн нийтийн, нийгмийн өмчид суурилсан нийгэм.	Малчдын; Ажилчдын; Сэхээтний; Номенклатура (дарга) ангийн бүтэцтэй
Хүснэгт-в	Олон мянгатад хуваагдсан хүмүүс бөгөөд цэрэгт мордох, өртөө хийх, их ав хоморгод оролцох зэргээр гол алба, үүрэг гүйцэтгэдэг.	Дээд давхраа – Чингис хааны алтан ураг, талын язгууртнууд; Жирийн иргэд /улсын иргэн; Харьяатан иргэн/
Хүснэгт-г	Сайн-д харц язгуурын түшмэд, дархад, тайж нарын хүргэн- тавнан, баян чинээлэг өрх багтдаг.	Сайн – харц язгуурын түшмэд; Дунд – чинээлэг хөрөнгөтэй, элч, хиа; Адаг – хар хүн хэмээх жирийн харц иргэд


- А. Хүснэгт-а В. Хүснэгт-б С. Хүснэгт-в D. Хүснэгт-г

5. Харь орны соёл, зай үйлийн онцлогт дасан зохицох явцад гардаг хүндрэл бэрхшээл буюу хүн өөрт дасал болоогүй харийн соёлд орох үед олон таагүй сөрөг мэдрэмжүүд үүсэж болох бөгөөд тэдгээрийн нэгдлийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- A. Соёлын дархлаа C. Соёлын эрх чөлөө
B. Соёлын адилсал D. Соёлын цочирдол

6. Аливаа соёл өөрийн өвөрмөц онцлогтой гэж үзэх бөгөөд тухайн соёлыг өөрийнх нь үнэт чанарын үүднээс тайлбарлах, өөрийн соёлтой адилтган хүндэтгэн авч үзэх зэрэг нь аль үзэлд хамаарах вэ? /1 оноо/
- A. Соёлын статик C. Соёлын динамик
B. Соёлын этноцентризм D. Соёлын релятивизм

7. Дараах тохиолдлыг уншаад “Харь соёлд дасан зохицох үе шат”-ын аль үе шат дээр явж буйг тодорхойлоорой. /2 оноо/

График №1 /Харь соёлд дасан зохицох үе шат/



A. C-үе шат

B. E-үе шат

C. F-үе шат

D. B-үе шат

Тохиолдол

Мико элсэлтийн шалгалтад 800 оноо авч тэтгэлгээр Япон улсад суралцахаар болсондоо маш их баяртай байлаа. Тэр Япон улсын Чүбү мужийн Нийгатад очсон тул цаг агаарын нөхцөл байдалд нь дасаж чадахгүй тав тухгүй байсан учир гэртээ буцаж очихыг маш ихээр хүсэж ганцаардаж эхэлсэн.

8. Өгөгдөлд байгаа эрдэмтдийг үзэл санаатай нь зөв байршуулна уу. /2 оноо/
- Өгөгдөл: /1- Э.Тайлор, 2-Э. Фромм, 3-Ж. Мердок, 4-Дж. Кэмпбелл, 5-Ж. Локк /

a.....	Эрх чөлөө бол хувь хүний өөрийгөө нээх, хувь чанараа хөгжүүлэх боломж мөн.
b.....	Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хугарсан нэгэн болгодог.
c.....	Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хясах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал мөн.

A. a4,b2,c5

B. a4,b2,c1

C. a3,b2,c5

D. a3,b1,c5

9. Дараах ойлголтуудаас хүний эрхэм чанарт аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- A. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг
B. Хүний эрхэм чанарыг нь салгаж болдог
C. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл
D. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй

10. Өмчлөх эрх үүсэх хуульд заасан үндэслэлүүдийг олоорой. /1 оноо/
- A. Эд хөрөнгө өв залгамжилж авах
B. Зээлээр худалдах, худалдан авах гэрээ
C. Ирээдүйд эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
D. Эд хөрөнгөө худалдан авах болзолтой хийсэн худалдан, худалдан авах гэрээ

11. Нэгэн дүүргийн иргэн Доржийн гэрийн ойролцоох шуудууг бөглөж шатахуун түгээх станц баригдсанаар тэр орчмын айлуудад зуны улиралд бороо орохоор үер болох аюул бий болж байгаа тул хаана, яаж хандвал зөв бэ? /2 оноо/
 А. Хорооны засаг даргад амаар хүсэлт гаргах нь зөв
 В. Дүүргийн газрын албанд амаар өргөдөл гаргах нь зөв
 С. Дүүргийн засаг даргад бичгээр гомдол гаргах нь зөв
 D. Дүүргийн шүүхэд бичгээр нэхэмжлэл гаргах нь зөв
12. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Тэгвэл өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ хэд болохыг тооцоорой. /2 оноо/
 А. 330,000 төгрөг В. 495,000 төгрөг С. 560,000 төгрөг D. 660,000 төгрөг
13. Захиргаадалтын эдийн засгийн тогтолцооны гол үүрэг нь аль вэ? /1 оноо/
 А. Хувийн өмч /үйлдвэрлэлийн хэрэгсэл/ С. Ашгийн хойноос хөөцөлдөх
 В. Төвлөрсөн төлөвлөлт D. Төрийн оролцоо хязгаарлагдмал
14. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү. /1 оноо/
-ын гол онцлог нь улс орны баялаг зөвхөн хөдөө аж ахуй, газар тариаланд л бүтээгддэг, тариаланчдын хөдөлмөр л бүтээлч хөдөлмөр гэж үздэг.
 А. Меркантизм С. Физиократизм
 В. Сонгодог эдийн засгийн онол D. Шинэ сонгодог онол
15. Дараах өгөгдлүүдээс “макро эдийн засаг”-ийн судлах зүйлсийг сонгоорой. /2 оноо/

1. Ажил эрхлэлтийн түвшин	2. Өрсөлдөөн	3. Ажилгүйдэл
4. Мөнгө, зээлийн асуудал	5. Эдийн засгийн өсөлт	6. Нийлүүлэлт

 А. 1, 2, 4, 5 В. 2, 3, 4, 5 С. 2, 4, 5, 6 D. 1, 3, 4, 5
16. Инфляцын эсрэг чиглэсэн үйл ажиллагаануудыг сонгоорой. /3 оноо/

1. Зээлдүүлэгчдэд хохирол учирна
2. Үнийг тогтворжуулах нөхцөлийг хязгаарлах
3. Татварын шинэчлэл хийх
4. Бүтээгдэхүүний үнэ өснө
5. Ажилгүйдэл өснө
6. Мөнгөний бодлогоор нөлөөлөх

 А. 2, 3, 6 В. 1, 2, 3 С. 1, 4, 5 D. 1, 2, 6
17. Төрийн зүгээс нийгмийн амьдралд хамгийн бага оролцоотой дэглэм бөгөөд үндсэн үүрэг нь хулгай, залилан, хүчирхийлэл зэргээс хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэдэг гэж үздэг дэглэм аль нь вэ? /1 оноо/
 А. Авторитар С. Либераль
 В. Охлократ D. Консерватив

18. Боловсон хүчний намын тухай ойлголтод аль нь хамаарах вэ? /1 оноо/
- A. Төрийн нийгмийн бодлогыг явуулах эрмэлзэлтэй. Доод хэсгийнхэн буюу ядуу хэсгийг ч дэмждэг.
 - B. Тухайн намын гишүүн болоход хатуу гишүүнчлэлгүй бөгөөд сонгуулийн үеэр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.
 - C. Төрийн бодлогыг хязгаарлахыг эрмэлздэг. Бизнес эрхлэгч, хувийн өмчтөн, дунд ангийнхныг дэмждэг.
 - D. Тухайн намын гишүүн болоход хатуу гишүүнчлэлтэй бөгөөд сонгуулийн бус үеэр ч үйл ажиллагаагаа явуулдаг.

19. Г.Алмондын тодорхойлсон улс төрийн системийн чиг үүргийг аль нь вэ? /1 оноо/
- A. Оролт; Гаралт
 - B. Шаардлага; Дэмжлэг
 - C. Дадал заншлын; Хууль зүйн
 - D. Артикуляци; Агрегаци; Интеграци

20. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

a) Улс төр b) Улс төрийн соёл c) Улс төрийн бодлого	1	Улс төрийн байгууллагууд, субъектүүдийн хооронд үүсдэг, эвлэлдэн нэгдэх, зөрчилдөх, сэргөлдөх зэрэг олон талт харилцааны цогц
	2	Улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас олон түмний түгээмэл эрх ашигт нийцсэн дайчлан гаргах, хуваарилах, зохицуулах, дэмжих чадвар бүхий тасралтгүй үйл явц
	3	Нийгмийн олон түвшинд шийдвэр гаргах, түүнд нөлөөлөх, эрх мэдлийг олж авах, түүний төлөө тэмцэлдэх, эрх мэдэлд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг үйл явц
	4	Улс төрийн амьдралд хандах хандлага, итгэл үнэмшил, чиг баримжааны нийлбэр цогц

- A. a3,b4,c2 B. a1,b4,c2 C. a2,b4,c3 D. a2,b1,c3

21. Нэгдсэн Үндэсний Байгууллагыг бий болгох санаа хэзээнээс эхэлсэн бэ? /1 оноо/
- A. Сирусийн бортого бий болсон үед /боолуудыг чөлөөлсөн үеэс/
 - B. Дэлхийн нэгдүгээр дайны дараа хүний эрх, эрх чөлөөг хангаж дээдлэхийн тулд
 - C. 1939-1945 оны үед болсон дэлхийн хоёр дугаар дайны үеийн хүнд бэрх өдрүүдэд
 - D. “Магна Харта” хэмээх тунхаг бичиг баталгаажуулснаар

22. Дараах өгөгдлүүдээс олон улсын эрх болон ёс зүйн хариуцлагын үйлчлэх хүрээний ангилалд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Орон нутгийн B. Бүс нутгийн C. Олон улсын D. Түгээмэл

23. Монгол улсын “Гуравдагч хөрш” орнуудын хамтын үйл ажиллагаа эхэлсэн он болон айлчилсан оныг зөв харгалзуулна уу. /2 оноо/

a) 2003 b) 2011 c) 2016	1	БНСУ-ын Хууль зүйн яамны Цагаачлалын албаны мэдээгээр Монгол улсын 35091 иргэн урт болон богино хугацаагаар байнга оршин суудаг гэсэн тоон үзүүлэлт онд гаргажээ.
	2	АНУ-ын дэмжлэг, буцалтгүй тусламжаар Таван толгойн цэргийн бэлтгэлийн баазад “Хааны эрэлд” цэргийн хамтарсан сургуулилалт..... оноос хэрэгжүүлж эхэлсэн.
	3	 онд Монгол улс болон БНСУ-тай “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүрсэн

A. a2b1c3

B. a2b3c1

C. a1b3c2

D. a3b2c1